



ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН  
ГАЗАР



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ДҮНГЭЭС

## 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭС...



НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН  
ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН  
**9,345.1 тэрбум төгрөг**



НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР  
ЗЭЭЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ  
**9,317.2 тэрбум төгрөг**



ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ  
**27.9 тэрбум төгрөг**

## ТЭНЦЭЛ (НЭГДСЭН ТӨСВИЙН БҮРЭЛДЭХҮҮН ТУС БҮРЭЭР)



УЛСЫН ТӨСВИЙН  
ТЭНЦЭЛ

**Алдагдал: 353.5 тэрбум төгрөг**



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН  
ТЭНЦЭЛ

**Ашиг: 6.6 тэрбум төгрөг**



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН ТЭНЦЭЛ

**Ашиг: 275.5 тэрбум төгрөг**



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН ТЭНЦЭЛ

**Ашиг: 99.3 тэрбум төгрөг**

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ДҮНГЭЭС

1. 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл
2. 2018 оны нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн гүйцэтгэл
3. 2018 оны нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл
4. 2018 оны нэгдсэн төсвийн цэвэр зээлийн гүйцэтгэл
5. 2018 оны нэгдсэн төсвийн тэнцэл
6. Засгийн газрын өр
7. Засгийн газрын гадаад өр
8. 2018 оны улсын төсвийн орлогын гүйцэтгэл
9. 2018 оны улсын төсвийн зарлагын гүйцэтгэл
10. 2018 оны улсын төсвийн зарлагатай холбоотой зөрчлүүдээс...
11. 2018 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэл
12. Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн гүйцэтгэл
13. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн гүйцэтгэл
14. Дүгнэлт
15. Аудитын зөвлөмж

### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хаяг: Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160, Монгол Улс

Утас: 51-263813

Факс: 323266, 324653

Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)

<http://audit.mn/>



# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС НЭГДСЭН ТӨСӨВ

## 2018 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ



Макро түвшний судалгаа, зах зээлийн гадаад, дотоод хүчин зүйлсийн үндэслэлийг бодитой тооцоолж, тусгаагүйгээс Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг батлахдаа өмнө баталсан төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилсөн байна.

2018 оны төсвийн хүрээний мэдэгдлийг УИХ баталснаас 5 сар гаруй хугацааны дараа Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувиас бусад бүх үзүүлэлтэд өөрчлөлт оруулсан байна.

### ХИЙГДСЭН ӨӨРЧЛӨЛТҮҮДЭЭС

#### ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР



**2,154.4 тэрбум**  
төгрөгөөр  
нэмэгдүүлсэн

#### ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО



**423.0 тэрбум**  
төгрөгөөр  
нэмэгдүүлсэн

#### НИЙТ ЗАРЛАГА



**200.5 тэрбум**  
төгрөгөөр  
нэмэгдүүлсэн

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ		ӨӨРЧЛӨЛТ
	2017.05.31	2017.11.14	ЗӨРҮҮ
Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ (хувь)	1.8	4.2	2.4
Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин (хувь)	6.1	8.6	2.5
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ (тэрбум төгрөг)	6,808.4	7,231.4	423.0
Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ (тэрбум төгрөг)	9,451.0	9,651.5	200.5
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл (тэрбум төгрөг)	-2,642.6	-2,420.1	222.5
Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ (тэрбум төгрөг)	1,623.0	1,928.5	305.5
Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр (тэрбум төгрөг)	22,155.2	24,309.6	2,154.4
Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ (тэрбум төгрөг)	499.6	646.0	146.4



Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт хийсэн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, ... дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасантай нийцээгүй байна.



**ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ:** Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг бодитой тооцож батлуулан төсвийн төлөвлөлтөд баримтлах талаар Засгийн газарт Үндэсний аудитын газраас өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.



# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## НЭГДСЭН ТӨСӨВ

### 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Нэгдсэн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 27.9 хувиар давж биелсэн ба эдийн засаг дахь татварын ачаалал өмнөх оноос 2.9 нэгж хувиар өссөн байна.

### НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН **10,172.8 ТЭРБУМ ТӨГРӨГ**

Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн

**9,345.1**  
тэрбум төгрөг

Тогтворжуулалтын сангийн орлого

**207.0**  
тэрбум төгрөг

Ирээдүйн өв сангийн орлого

**620.7**  
тэрбум төгрөг

### НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

Улсын төсвийн орлого  
7,656.1 тэрбум төг

Орон нутгийн төсвийн орлого  
2,769.3 тэрбум төг

Нийгмийн даатгалын сангийн орлого  
2,090.1 тэрбум төг


Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого  
411.1 тэрбум төг

НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО **9,345.1 ТЭРБУМ ТӨГРӨГ**

**88.0%** ■ Татварын орлого 8,227.8 тэрбум төгрөг | **12.0%** ■ Татварын бус орлого 1,117.3 тэрбум төгрөг

### ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТАТВАРЫН АЧААЛАЛ

#### Татварын ачаалал (тэрбум төгрөг)



**ДНБ-д эзлэх татварын ачаалал 2018 онд өмнөх оноос 2.9 нэгж хувиар өссөн**

2018 онд ДНБ-ий хэмжээ өмнөх оноос 6.9 хувиар өсч, харин ДНБ-д эзлэх татварын ачаалал 25.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 2.9 нэгж хувиар өссөн байна.

### ТАТВАРЫН ОРЛОГО

Татварын орлого 2018 онд өмнөх оноос 1,912.6 тэрбум төгрөгөөр илүү байна.

### ТАТВАРЫН ОРЛОГЫН ӨСӨЛТӨД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС



Эдийн засгийн өсөлт  
6.9%

Зэсийн баяжмалын экспорт

Экспорт 1436.7 мянган тн  
Жилийн дундаж үнэ (тн тутамд) 6,524.8 ам.доллар

Нүүрсний экспорт

Экспорт 36.2 сая тн  
Үнийн өсөлт (дундаж) 44.0%

НӨАТ-ын цахим төлбөрийн баримтын тоо 289.2 сая

Нийт бараа эргэлтийн өсөлт 23.6%

ААНОАТ-ын дутуу төлөлтийн барагдуулалтын орлого 166.0 тэрбум төг



# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС НЭГДСЭН ТӨСӨВ

## 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 92.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

### 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ (ЦЭВЭР ДҮНГЭЭР)

**9,317.2 ТЭРБУМ ТӨГРӨГ**



### НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДУТУУ ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН

**717.9 ТЭРБУМ ТӨГРӨГ**

УРСГАЛ ЗАРЛАГЫН ДУТУУ ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН  
**337.7 тэрбум төгрөг**

ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ДУТУУ ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН  
**378.1 тэрбум төгрөг**

ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ЗАРДЛЫН ДУТУУ ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН  
**2.1 тэрбум төгрөг**

### УРСГАЛ ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ



### ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД:

- Бариа, үйлчилгээний зардал**  
186.1 тэрбум төгрөгөөр өссөн
- Татаас ба урсгал шилжүүлэг**  
231.1 тэрбум төгрөгөөр өссөн
- Хүүгийн зардал**  
110.1 тэрбум төгрөгөөр буурсан





# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## НЭГДСЭН ТӨСӨВ

### 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ



#### ЗЭЭЛ ОЛГОЛТ

**419.1**

тэрбум төгрөг

Улсын төсвийн 6 ерөнхийлөн захирагч болон орон нутгийн төсвийн 15 ерөнхийлөн захирагч нарт 419.1 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх зээл олгосон.



#### ЗЭЭЛИЙН БУЦААН ТӨЛӨЛТ

**132.6**

тэрбум төгрөг

Төсвийн ерөнхийлөн захирагчдад өмнөх онуудад олгосон зээлээс 132.6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зээлийн төлөвлөгөөг 97.0 тэрбум төгрөгөөр буюу 42.2 хувиар дутуу биелүүлсэн.

### ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ (Төсвийн ерөнхийлөн захирагчдаар)

Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ)	Төсөл, хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө (тэрбум төгрөг)	Гүйцэтгэл	Зөрүү	Тэмдэглэл
<b>Олгосон зээл, үүнээс</b>		<b>518.2</b>	<b>419.1</b>	<b>(99.1)</b>	
Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайд	Боловсролын зээлийн сан	96.8	32.5	(64.3)	
Сангийн сайд	Олгох зээл (9 төсөл, арга хэмжээ)	201.7	186.9	(14.8)	
Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” сан	22.9	15.9	(7.0)	
Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайд	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	97.8	96.3	(1.5)	Зээл олголт дутуу
	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	22.0	20.0	(2.0)	
	Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл	1.8		(1.8)	
ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих болон бусад төсөл		5.1		(5.1)	
	УБ хотын VII, XIV хорооллын орон сууцны хорооллын болон Зүүн, өмнөд говийн хот, хил орчмын хотын хөгжил төсөл	13.0	21.5	8.5	Зээл олголт хэтэрсэн
Эрчим хүчний сайд	Олгох зээл (4 төсөл, арга хэмжээ)	21.9	21.5	(0.4)	Зээл олголт дутуу
Орон нутгийн ТЭЗ	15 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид	35.2	24.5	(10.7)	
<b>Буцаан төлөгдсөн зээл, үүнээс</b>		<b>(229.6)</b>	<b>(132.6)</b>	<b>(97.0)</b>	
Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайд	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	(137.4)	(74.1)	(63.3)	Зээлийн буцаан төвлөрүүлэлт дутуу
	Тариалан эрхлэлтийг дэмжих сан				
	Мал хамгаалах сан				
Хууль зүй, дотоод хэргийн сайд	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба	(20.6)	0.0	(20.6)	
Сангийн сайд	ААНБ болон улс, орон нутгийн төсөвт байгууллагууд, төсөл	(71.6)	(58.5)	(13.1)	
<b>Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн</b>		<b>288.6</b>	<b>286.5</b>	<b>(2.1)</b>	



# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС НЭГДСЭН ТӨСӨВ

## 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Тэнцлийг нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн тус бүрээр авч үзвэл, улсын төсөв алдагдалтай, орон нутгийн, Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв тус бүр ашигтай байна.

### ТЭНЦЭЛ (нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн тус бүрээр)



### НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ НӨХӨХ ЗОРИЛГООР БҮРДҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР



### ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС, ГАДААД ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ 2018 ОНД



Засгийн газрын  
үнэт цаасны  
эргэн төлөлт  
**2,434.7**  
тэрбум төгрөг



Засгийн газрын  
гадаад зээлийн  
эргэн төлөлт  
**280.2**  
тэрбум төгрөг




# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС НЭГДСЭН ТӨСӨВ

## ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (2018 оны жилийн эцсийн байдлаар)

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 22,367.0 тэрбум төгрөгт хүрчээ.



### ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН НИЙТ ҮЛДЭГДЭЛ, 2016-2018 ОН

(нэрлэсэн үнээр, тэрбум төгрөг)



2016-2018 онд Засгийн газрын гадаад өр өссөн бол, дотоод өр буурсан байна.


### ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БҮТЭЦ (2018 он)



Засгийн газрын 2018 оны өрийн үлдэгдлийн **89.4** хувийг гадаад өр, **10.6** хувийг дотоод өр эзэлж байна. Нэрлэсэн үнээрх гадаад өр **19,996.3 тэрбум төгрөг**, дотоод өр **2,370.7 тэрбум төгрөг** байна.

### ӨР (бүрэлдэхүүн хэсгүүдээр, 2018 он)

(нэрлэсэн үнээр, тэрбум төгрөг)



Засгийн газрын өрийг бүрэлдэхүүн хэсгүүдээр нь авч үзвэл, гадаад зээл (11.2 их наяд төгрөг) болон гадаад үнэт цаас (7.7 их наяд төгрөг) хамгийн өндөр дүнтэй байна. Нийт өрийн 50.1 хувийг гадаад зээл, 34.2 хувийг гадаад үнэт цаас эзэлж байна.





# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС НЭГДСЭН ТӨСӨВ

## ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ӨР (2018 оны жилийн эцсийн байдлаар)

**ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ**  
(нэрлэсэн үнээр, 2018 оны жилийн эцсийн байдлаар)

**19,966.3 тэрбум төгрөг**


Засгийн газрын гадаад өр 2017 оны жилийн эцсийн байдлаар нэрлэсэн үнээр 18,521.5 тэрбум төгрөг байсан бол 2018 оны жилийн эцсийн байдлаар 19,966.3 тэрбум төгрөг болж, 1,474.8 тэрбум төгрөгөөр өсжээ.

### ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ

#### НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР



#### (НЭРЛЭСЭН ҮНЭЭР, ТЭРБУМ ТӨГРӨГ)



Засгийн газрын гадаад өрийн 56 хувь нь зээл, 38 хувь нь үнэт цаас, 6 хувь нь өрийн баталгаа байна.

### ГАДААД ЗЭЭЛ




#### ГАДААД ЗЭЭЛИЙН ӨСӨЛТ


**2,044.9 тэрбум төгрөг**

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл өмнөх онд 9,156.2 тэрбум төгрөг байснаас тайлант онд 11,201.1 тэрбум төгрөгт хүрч, 2,044.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

#### Гадаад зээлийн эцсийн үлдэгдэл (тэрбум төгрөг)




#### Гадаад зээлийн ашиглалт 2018 онд (тэрбум төгрөг)



Засгийн газар 2018 онд 61 төсөлд 1,490.3 тэрбум төгрөгийн гадаад зээлийг авч ашигласан.

### ГАДААД ҮНЭТ ЦААС

#### Эцсийн үлдэгдэл (тэрбум төгрөг)



### ӨРИЙН БАТАЛГАА

#### Эцсийн үлдэгдэл (тэрбум төгрөг)





# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС УЛСЫН ТӨСӨВ

## 2018 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ



2018 оны улсын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн өмнөх оны гүйцэтгэлээс 1,799.0 тэрбум төгрөгөөр өсөхөд экспорт, импорт нэмэгдсэн, ААНОАТ-ын болон НӨАТ-ын орлого өссөн нь тус тус нөлөөлжээ.

## 2018 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ

2018 ОНЫ НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ӨСӨЛТ **1,799.0 ТЭРБУМ ТӨГРӨГ**



2018 онд нийт орлого ба тусламжийн дүн **7,656.1 тэрбум** төгрөгт хүрсэн нь өмнөх оны гүйцэтгэлээс **1,799.0 тэрбум** төгрөгөөр өссөн байна.

## ОРЛОГЫН БҮТЭЦ

НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН **7,656.1 ТЭРБУМ ТӨГРӨГ**

Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж

**6,828.4 тэрбум төгрөг**



Өмнөх оны гүйцэтгэлээс **1,654.7 тэрбум** төгрөгөөр өссөн.

Тогтворжуулалтын сангийн орлого

**207.0 тэрбум төгрөг**



Өмнөх оноос **118.7 тэрбум** төгрөгөөр буурсан.



Ирээдүйн өв сангийн орлого

**620.7 тэрбум төгрөг**



Өмнөх оноос **263.0 тэрбум** төгрөгөөр өссөн.

## НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭР


ТАТВАРЫН ОРЛОГО **79.5%**



5,430.6 ТЭРБУМ ТӨГРӨГ

Өмнөх оны гүйцэтгэлээс **1,443.4 тэрбум** төгрөгөөр өссөн.

### ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ



### ТАТВАРЫН ОРЛОГО НЭМЭГДЭХЭД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Экспорт өмнөх оноос 13.1 хувиар, импорт 35.5 хувиар өссөн, ААНОАТ-ын орлого 84.7 хувиар, НӨАТ-ын орлого 44.7 хувиар давж биелсэн.

ТАТВАРЫН БУС ОРЛОГО **20.5%**



1,397.8 ТЭРБУМ ТӨГРӨГ

Өмнөх оны гүйцэтгэлээс **211.3 тэрбум** төгрөгөөр өссөн.



Татварын бус орлогыг 147.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг алдсан байна. ТӨБЗГ дараах орлогыг 2018 оны тогтоол, шийдвэрт тусгаж, төвлөрүүлээгүй байна. Үүнд:



“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангаарх 480.3 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас 2018 онд улсын төсөвт төвлөрүүлэх 144.1 тэрбум төгрөгийн орлого



“Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангаарх 10.1 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас 2018 онд улсын төсөвт төвлөрүүлэх 3.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлого



# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## УЛСЫН ТӨСӨВ

### 2018 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ


#### ГҮЙЦЭТГЭЛ (тэрбум төг)



Өмнөх оноос урсгал зарлага 189.4 тэрбум төгрөгөөр өсөж, хөрөнгийн зардал 116.0 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээл 31.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан.

#### ЗАРЛАГЫН БҮТЭЦ

Урсгал зарлага  
79.6%



Хөрөнгийн зардал  
16.8%

Эргэж төлөгдөх  
цэвэр зээл  
3.6%

#### ГҮЙЦЭТГЭЛ (зарлагын бүтцээр, хувиар)



Хөрөнгийн зарлагын гүйцэтгэл 81.3 хувь байна.

#### ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ



ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.



### ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧЛҮҮДЭЭС

ТӨСВИЙН ТӨСЛИЙН САНАЛ



ТӨСВИЙН ХЯЗГААР

БАТЛАГДСАН ТӨСӨВ

Зарим төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ) төсвийн төслийн саналаа Сангийн яаманд ирүүлэхдээ төсвийн зарлагын хязгаарыг баримтлалгүйгээр давуулан төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 14.2.1-д "жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн зарим ТЕЗ-ийн төсвийг хязгаараас их хэмжээний хэлбэлзэлтэй баталсан байна.

- Төсөв нь хязгаараас их хэмжээний хэлбэлзэлтэй батлагдсан ТЕЗ:
  - БСШУСС-ын төсөв 345.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;
  - ХНХС-ын төсөв 195.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;
  - Сангийн сайдын төсөв 553.3 тэрбум төгрөгөөр буурсан.
- Төсвийн хязгаараас хэтрүүлэн тооцсон зарим ТЕЗ-ийн тайлбар, шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний болон нэг удаагийн шинж чанартай зардлын тооцоолол, үндэслэл хангалтгүй байна.
- Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагыг төлөвлөхөд баримталж буй журмаар тогтоосон зарим зардлын эдийн засгийн ангиллыг хэрэглэх заавар тодорхойгүйгээс тухайлсан зардал, хөтөлбөр, арга хэмжээ, төслүүдийн төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөөгүй байна.
- Зарим ТЕЗ-ийн ирүүлсэн төсвийн саналд тусгасан хөтөлбөр, арга хэмжээний зардлыг холбогдох эрх зүйн актууд, бодит тоо мэдээ, нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслэн боловсруулаагүй, хяналтыг хэрэгжүүлээгүй байна.



# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС УЛСЫН ТӨСӨВ

## 2018 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГАТАЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧЛҮҮДЭЭС...

### ЭРХ ЗҮЙН АКТЫГ БАРИМТЛААГҮЙГЭЭС ГАРСАН ЗӨРЧЛҮҮДЭЭС



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан - Орон нутаг, нийслэлд хэрэгжүүлсэн зорилтот төслийг Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөл хөтөлбөрт **2,115.0 сая** төгрөгийн санхүүжилт олгосон.



“Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт” төсөл **972.8 сая** төгрөгийг зохих шийдвэргүйгээр зарцуулсан.



“Хөдөлмөр эрхлэх үр чадварыг сайжруулах” төсөл **20.3 сая** төгрөгийг зохих шийдвэргүйгээр зарцуулсан.



Үндэсний брендийн бодлогын зөвлөлийн ажлын алба - Нэр бүхий 8 аж ахуйн нэгжтэй байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-нд заасан хугацаа дуусаагүй, ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад **449.7 сая** төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон.



Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2013–2018 онд Дэлхийн шилдэг их, дээд сургуулиудын бакалаврын хөтөлбөрт хамрагдсан 2 суралцагчийг 2018 онд дахин магистрын хөтөлбөрт хамруулан **32.0 мянган ам.долларын** санхүүжилтийг олгосон.



ГХС - Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгөнөөс Сангийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэлгүй **61.3 сая** төгрөгийг зарцуулсан.



ШЕЗ-ийн ажлын алба **302.5 сая** төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй.

### ЦАЛИН ХӨЛС, УРАМШУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧЛҮҮДЭЭС



Зэвсэгт хүчний анги, салбарын санхүүгийн ажилтан цалингийн зардлаас нийт **445.3 сая**, Дорноговь аймгийн Прокурорын газрын нягтлан бодогч **11.5 сая** төгрөгийг тус тус ашиглан шамшигдуулсан.



Хууль зүйн туслалцааны төвийн захирал тушаал гарган захирал, нягтлан бодогч нар 2018 оны ажлын үр дүнгээ **200** хувиар тооцон үр дүнгийн урамшуулал, илүү цагийн хөлс авсан.



“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл батлагдсан орон тооноос **4** ажилтан илүү ажиллуулсан.



Зарим төсвийн захирагч цалингийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас олгосон байна.

### ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛТАЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧЛҮҮДЭЭС



СЗХ- томилолтын зардлаас тээвэр шатахууны зардалд **11.9 сая** төгрөгийг шилжүүлсэн, томилолтын урьдчилгаанд **6.5 сая** төгрөгийг олгосон боловч томилолтоор ажиллаагүй.



“Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл гадаад томилолтын **43.4 сая** төгрөгийг батлагдаагүй зардал гаргасан.



“Мянганы сорилтын корпораци”-ийн Үндэсний ажлын албаны дарга ГХС-ын тушаал шийдвэргүй, томилолтын зардлын төсөв батлуулалгүйгээр **19.1 сая** төгрөгийг зарцуулсан.

### БУСАД



Зарим ТЕЗ-д хөтөлбөр, арга хэмжээний хүрсэн үр дүнг төсөвтэй уялдуулан тайлагнаагүй, төсвийн зарцуулалтын талаарх тайлбарыг бүрэн гаргаагүй, төсвийн зарлагын бодит хэмнэлтийг тооцоогүй байна.




Сангийн сайдын 2008 оны 352 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан”, 2012 оны 76 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын маяг” нь Сангийн сайдын тушаалаар баталсан эдийн засгийн ангилал, санхүүгийн тайлангийн Э-тайлан программтай уялдаагүй байна.



# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

### 2018 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



#### НИЙТ ОРЛОГО **2,769.3 ТЭРБУМ ТӨГРӨГ**




(тэрбум төг)

Татварын орлого  
**1,158.8**

Татварын бус орлого  
**1,610.5**


#### ОРЛОГЫН БҮТЭЦ



#### НИЙТ ЗАРЛАГА **2,762.7 ТЭРБУМ ТӨГРӨГ**



#### НИЙТ ЗАРЛАГЫН БҮТЭЦ



#### УРСГАЛ ЗАРЛАГЫН БҮТЭЦ



### ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЗӨРЧЛӨӨС



Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа зарим байгууллагууд холбогдох хууль, эрх зүйн актыг бүрэн мөрдөөгүй, төсвийг үр ашигтай, зөв зохистой зарцуулаагүйгээс нийт **2.2 тэрбум** төгрөгийн зөрчил илэрсэн байна.

#### ТӨСВИЙГ ҮРЭЛГЭН, ЗОРИУЛАЛТ БУСААР ЗАРЦУУЛСАН ОРОН НУТАГ (мөнгөн дүн)

	Нийслэл <b>1,619.1 сая төгрөг</b>		Төв аймаг <b>71.0 сая төгрөг</b>
	Сэлэнгэ аймаг <b>153.5 сая төгрөг</b>		Говьсүмбэр аймаг <b>70.0 сая төгрөг</b>
	Сүхбаатар аймаг <b>141.0 сая төгрөг</b>		Хөвсгөл аймаг <b>61.5 сая төгрөг</b>
	Орхон аймаг <b>97.0 сая төгрөг</b>		Хэнтий аймаг <b>34.1 сая төгрөг</b>






# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН


### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

 Нийгмийн даатгалын сан 2018 онд улсын төсвөөс **609.8 тэрбум** төгрөгийн санхүүжилт авчээ.

#### ОРЛОГО

НИЙТ ОРЛОГО **2,090.1 ТЭРБУМ ТӨГРӨГ**

##### ОРЛОГЫН БҮТЭЦ (тэрбум төгрөг)



УЛСЫН ТӨСВИЙН **609.8 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН** САНХҮҮЖИЛТИЙН ЗОРИУЛАЛТ

ЗОРИУЛАЛТ	МӨНГӨН ДҮН
 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэр	<b>227.8</b> тэрбум төгрөг
 Цэргийн тэтгэвэр	<b>122.9</b> тэрбум төгрөг
 Тэтгэвэрийн даатгалын сангийн алдагдлыг нөхөх	<b>259.1</b> тэрбум төгрөг

ХҮҮГИЙН НИЙТ ОРЛОГО **74.6 ТЭРБУМ ТӨГРӨГ**



Хадгаламжийн хүүгийн орлого  
**56.7 тэрбум төгрөг**



Харилцах дансны үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлого  
**15.6 тэрбум төгрөг**




Бондын хүүгийн орлого  
**2.3 тэрбум төгрөг**

#### ЗАРЛАГА

НИЙТ ЗАРЛАГА **1,814.6 ИХ НАЯД ТӨГРӨГ**

##### ЗАРЛАГЫН БҮТЭЦ (тэрбум төгрөг)



Нийгмийн даатгалын сан **6.3 тэрбум** төгрөгөөр төсөв хэтрүүлэн зарцуулжээ. Төсөв хэтрэхэд тэтгэмжийн даатгалын сангийн төсөв **9.7** тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь нөлөөлжээ. Энэ нь Нийслэлийн төвийн дүүргүүдэд тэтгэмж авагчдын тоо **11.2** мянган хүнээр нэмэгдсэнээр Нийслэлийн тэтгэмжийн даатгалын сангийн зардал **6.8** тэрбум төгрөгөөр хэтэрсэнтэй холбоотой байна.



# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ



ЭМД-ийн Ерөнхий газар 2018 онд нийт 160 орон тоотой ажилласан нь УИХ-ын НББСШУ-ны Байнгын хороо, Засгийн газрын баталсан дээд хязгаараас 92-оор хэтэрчээ.

#### САНГИЙН ОРЛОГО

НИЙТ ОРЛОГО **411.1 ТЭРБУМ ТӨГРӨГ**

ЭМД-д ХАМРАГДАЛТ **88.9%**



Даатгалд хамрагдсан иргэдийн тоо: **2,824.7 мянга**




Даатгалд хамрагдаагүй иргэдийн тоо: **350.0 мянга**

ОРЛОГЫН БҮТЭЦ

Бусад орлого - 11.6%

Төр хариуцах иргэдийн төлсөн шимтгэл - 16.4%

Сайн дурын даатгалд хамрагдагсад - 4%



Ажил олгогч, даатгуулагчид **68%**

#### САНГИЙН ЗАРЛАГА БА ТЭНЦЭЛ

НИЙТ ЗАРЛАГА

**311.7**

тэрбум төгрөг

ЗАРЛАГЫН БҮТЭЦ

213.2

94.9

3.4

0.2

Төрийн өмчийн ЭМБ-дод олгох

Хувийн эмнэлэг, эмийн санд олгох

Үйл ажиллагааны урсгал зардал

Бусад

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

**99.3**

тэрбум төгрөгийн ашигтай

#### ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АЖИЛЛАГСДЫН ТОО

БАТЛАГДСАН ОРОН ТОО

ГҮЙЦЭТГЭЛ



УИХ, Засгийн газраас баталсан орон тоо

**68**



САНГИЙН ЯАМ

Сангийн яамны хянасан төсвийн хуваариар төлөвлөсөн нийт ажиллагсдын тоо

**90**



ЭМД-ийн Үндэсний зөвлөлөөс баталсан орон тоо

**152**



Нийт ажиллагсдын тоо

**160**

ЭМД-ийн Үндэсний зөвлөлийн ажлын албаны орон тоо: **13**  
ЭМД-ийн Ерөнхий газрын орон тоо: **55**

Эрх бүхий байгууллагаас тогтоосон орон тооноос **22-оор илүү** төлөвлөсөн.

Төрийн захиргааны албан хаагчдын тоо: **90**  
Гэрээт ажилтны тоо: **49**

УИХ, Засгийн газрын баталсан дээд хязгаараас **92** орон тоо хэтрүүлэн ажилласан.



### ДҮГНЭЛТ

1. Макро түвшний судалгаа, зах зээлийн гадаад, дотоод хүчин зүйлсийн үндэслэлийг бодитой тооцоолж, тусгаагүйгээс Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг батлахдаа өмнө баталсан төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилсөн байна.
2. Уул уурхайн голлох нэрийн бүтээгдэхүүний үнэ өссөн, татварын бүртгэл, мэдээллийн системийн хамрагдалт сайжирсан, татварын суурийг өргөжүүлсэн, Засгийн газрын авч хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд экспорт нэмэгдсэн зэрэг шалтгааны улмаас төсвийн татварын орлого төлөвлөснөөс бүх нэр төрлөөр давж биелжээ.
3. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсанаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар ногдол ашгийн төлөвлөгөөг 31.6 тэрбум төгрөгөөр дутуу тооцож тогтоол, шийдвэр гаргасан нь тухайн орлого тасрахад нөлөөлсөн, өмнөх онд ашигтай ажилласан төрийн өмчийн зарим компанийн ногдол ашгийг тооцож, төвлөрүүлээгүйгээс төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.
4. Төсвийн төлөвлөлт болон тайлагналтай холбоотой журам, заавар, програм хангамжийн уялдаа хангалтгүй байгаа нь төсвийн зарцуулалтыг хянах боломжийг сулруулж байна.
5. Зарим төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн дотоод хяналтын бүтэц, орон тоо, зохион байгуулалт сул байгаагаас хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдахад хүргэж байна.
6. Улсын төсвийн эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал төлөвлөснөөс 8.5 тэрбум төгрөг буюу 3.3 хувиар хэтэрсэн нь зарим ТЕЗ-д өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
7. Төсвийн тогтворжилтыг хангаж, орлого төлөвлөсөн хэмжээнээс давж биелснээр нэгдсэн төсвийн тэнцэл 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.
8. Засгийн газрын өрийн үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 22,367.0 тэрбум төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн дүн ба урьдчилан тооцсон ДНБ-ий харьцаа 58.9 хувьтай тэнцэж, өмнөх оноос 13.6 нэгж хувиар буурсан байна.
9. Аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц санд журмын дагуу нөөцөд байвал зохих үлдэгдлийг

байршуулаагүй, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

10. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хөрөнгө оруулалтын ажлууд он дамжин хэрэгжиж, гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосноос зардлын бодит бус хэмнэлт үүсжээ.

11. Нэмэлт төсвийн дансад зарим зориулалтын бус орлого төвлөрүүлэн зарцуулж, тайлагнасан нь нэмэлт төсвийн орлого, зарлагын дүн буруу илэрхийлэгдэх нөхцөлийг бий болгох эрсдэлтэй байна.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан нийт орлого ба тусламжийн 10,172.8 тэрбум, нийт зарлага ба цэвэр зээлийн 9,317.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар төсвийн тогтвортой байдлыг хангах хуулийн шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 2018 оны төсвийг боловсруулж батлахдаа Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах асуудал давтагдсан байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ААНБ-уудын ногдол ашгийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэх талаар ТӨБЗГ-ын даргад өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүйгээс Монгол Улсын 2018 оны төсөвт батлагдсан ногдол ашгийн орлогын төлөвлөгөө 32.4 тэрбум төгрөгөөр тасарчээ.

Иймд Төрийн аудитын байгууллагын аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэхээр холбогдох албан тушаалтны боловсруулсан төлөвлөгөө, түүний хэрэгжилт, үр дүнг УИХ-ын Төсвийн Байнгын хороогоор хэлэлцүүлэн төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гаргуулах саналыг уламжилж байна.



# МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГААС НЭГДСЭН ТӨСӨВ

## АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТЭД ҮНДЭСЛЭН ДАРААХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙГ ДОР ДУРДСАН АЛБАН ТУШААЛТАНД ЗӨВЛӨЖ БАЙНА. ҮҮНД:



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР  
САНГИЙН ЯАМ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын хариуцлагыг дээшлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, дотоод хяналт, дотоод аудитын үр нөлөөг сайжруулах;
2. Улсын төсвөөс олгосон зээлийн эргэн төлөлтийг барагдуулах талаар тодорхой шийдвэр гаргаж, үе шаттай ажил зохион байгуулах;
3. Төсвийн тухай хуулиар батлагдсан ногдол ашгийн төлөвлөгөөг дутуу тооцож тогтоол, шийдвэр гаргасан болон ашигтай ажилласан төрийн өмчит компаниудын ногдол ашгийг төсөвт төвлөрүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүй албан тушаалтнуудтай хариуцлага тооцох;
4. Аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц сан, Сум хөгжүүлэх сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах.

### САНГИЙН САЙДАД:

1. Төсвийн орлогыг бүрэн дайчлах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зардлын үр ашгийг сайжруулах чиглэлээр тооцооллыг хянаж төсөвт тусгах, орлого төвлөрүүлэгч байгууллагуудын ажлын уялдааг хангах;
2. Төсвийн төлөвлөлт болон хэрэгжилт, тайлагналын талаарх журам заавар, программ хангамжийн уялдааг хангах, шинэчлэн баталж мөрдүүлэх;
3. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн төлөвлөлт, тайлагналын уялдааг хангах бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
4. Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд холбогдох журамд зааснаас бусад дансдын орлого зарлагыг хамруулж нэгтгэн тайлагнахгүй байх.